



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/218

Ховд

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн  
2022 оны улсын тооллогын комисс байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 9, 46 дугаар тогтоол, 2021 оны 278 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын нэгдсэн үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч

Гишүүд: Б.Сандагсүрэн - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Ч.Багдал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Х.Болдбаатар - Төрийн аудитын газрын дарга

Г.Өөдэй - Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

Э.Дөлбадрал - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

С.Хоролсүрэн - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

А.Энхмөнх - Авто тээврийн төвийн дарга

Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Л.Ариунаа - Статистикийн хэлтсийн дарга

- Бүх сумдын Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нар
- Ц.Давааням - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч
- Б.Батнасан - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
- Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
- Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Х.Алтанцэцэг - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Н.Эрдэнэцэцэг - Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн
- Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн
- Д.Дариймаа - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн
- Д.Нямдорж - Боловсрол, соёл урлагийн газрын нягтлан бодогч
- Б.Далайбаяр - Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэн


Нарийн бичгийн

дарга: Ш.Нохойжав - Орон нутгийн өмчийн газрын дарга

2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогыг удирдан зохион байгуулж, сум байгууллагын салбар комисст арга зүйн туслалцаа үзүүлж үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргуулж мөрдүүлэх, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллоготой холбогдуулан зарцуулах хөрөнгө санхүүгийн асуудлыг хугацаа алдалгүй шийдвэрлүүлэх, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын тооллогод хамруулах хуулийн этгээдийн нэр, тэдгээрийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцооны хувь, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар болон бусад холбогдох мэдээллийг [egazaar.mn](http://egazaar.mn), [urban.gov.mn](http://urban.gov.mn), [e-mongolia](http://e-mongolia), төрийн цахим мэдээллийн нэгдсэн сан, “хур” системээс авах, мэргэжлийн байгууллагын оролцоотой гаргаж тооллогын ажилд ашиглах, улсын төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр бий болсон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг тооллогод бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах, үзлэг



тооллого хийх үеэр орон нутгийн өмчит хуулийн эдгээдийн эзэмшилд байгаа ашиглалтгүй болон илүүдэлтэй үндсэн хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан эд хөрөнгийг газар дээр нь үзэж, тоолж, худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах талаар зохих журмын дүгнэлт гаргуулан шийдвэрлүүлэх, орон нутгийн өмчийн тооллогыг 2022 оны 07 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулж, нэгдсэн дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 08 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэхийг тооллогын комиссын дарга (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.

ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

